



**БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БИЧМЭЛ ТАЙЛАН**

2023 он



АГУУЛГА

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар.....	2
1.2. Байгууллагын хүний нөөцийн талаар.....	2
1.3. Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд	3
1.4. Хяналт шалгалтын чиглэлээр	3
1.5. Иргэний бүртгэлийн чиглэлээр	4-5
1.6. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр	5-6
1.7. Санхүүгийн чиглэлээр	6
1.8. Архивын үйл ажиллагааны чиглэлээр	6-8
1.9. Мэдээлэл технологийн чиглэлээр	9

ХОЁР. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР	9-10
---	-------------

ГУРАВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР	11-12
--	--------------



НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар:

Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулан бүртгэлийн үнэн зөв байдлыг ханган 2023 оны эхний хагас жилийн байдлаар 28 албан хаагчтайгаар иргэний улсын бүртгэл, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр Булган аймгийн 1 тосгон 16 сумын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Тус хэлтэст 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт ирсэн албан бичиг 402, үүнээс хариутай 235 албан бичгийн 233 албан бичгийг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Хугацаа болоогүй 2 албан бичиг байгаа бөгөөд явуулсан албан бичиг 433, өргөдөл гомдол нийт 20 ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 18, хуулийн хугацаа болоогүй 2 өргөдлийг хянан шалгаж байна.

1.2. Байгууллагын хүний нөөцийн талаар:

2023 оны эхний хагас жилийн байдлаар УБЕГ-аас тус хэлтэст холбогдуулан ирүүлсэн 37 тушаал байгаагаас А тушаал 20, Б тушаал 17 байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган хэлтсийн 8 албан хаагч УТИС-ийг “Эрх зүйч” мэргэжлээр суралцаж амжилттай төгссөн.

Хэлтсийн хяналтын улсын байцаагч, Булган сумын иргэний бүртгэлийн улсын бүртгэгч, Хангал сумын иргэний бүртгэлийн улсын бүртгэгчийн сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг журмын дагуу зарлуулж хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

1.3. Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд:

Дотооддоо зохион байгуулах нийт ажилтан албан хаагчдыг хамруулсан сургалтын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд төлөвлөгөөний дагуу 2023.03.15-ны өдөр нийт 19 улсын бүртгэгч ТҮ-ний 5 албан хаагчдыг хамруулсан нэгдсэн арга зүйгээр хангах сургалтыг танхимаар зохион байгуулсан.



Аймгийн ЗДТГ, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас хамтран зохион байгуулсан “Дотоодын шилжилт хөдөлгөөн”-ний талаарх сургалт зөвлөгөөнд хэлтсийн 22 албан хаагч хамрагдаж мэдээлэл арга зүйгээр хангагдсан.



Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаж буй 7/4/10-ын нийт 9 удаагийн цахим сургалтад улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулж, Булган аймгаас зохион байгуулагдсан 3 удаагийн сургалтанд 30 албан хаагч, дотооддоо зохион байгуулсан 1 удаагийн танхим, 8 удаагийн цахим сургалтад нийт 18 албан хаагч, иргэн-төрийн байгууллага руу чиглэсэн сургалтад 30 гаруй иргэн, албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан байна.

1.4. Хяналт шалгалтын чиглэлээр:

Хяналт шалгалт хийж гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөөний дагуу бүртгэлийн хяналт шалгалтыг түүвэрчилсэн байдлаар 1139 бүртгэлд хийсэн. Үүнээс:

- ИУБ чиглэлээр - 179

- ЭХЭУБ чиглэлээр - 584

- ХЭБ чиглэлээр - 421 бүртгэлд хяналт шалгалт хийгдэж нийт 219 бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэн бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтлан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих зорилгоор улсын бүртгэгч нарын 1-р улиралд олгосон нийт лавлагаанд хяналт тавьж гарсан алдаа, зөрчлийн талаар анхааруулах сургалтыг 2023.04.24-ний өдөр цахимаар хийж, чиглэл боловсруулан дотоод албан бичгээр хүргүүлж Мөн өдөр тутмын ажил үйлчилгээнд хяналт тавьж иргэний улсын бүртгэлийн чиглэлээр бүртгэгдсэн бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цахимжуулалтыг тухай бүр хянан илүү, дутуу, буруу цахимжуулсан зөрчлүүдийг тухай бүр засч улсын бүртгэгч нарт чиглэл хүргэн ажиллаж байна.



1.5. Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Нийт хөтөлсөн бүртгэл

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2023 оны эхний хагас жилийн байлдаар нийт **3976** бүртгэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс: төрөлт 428, үрчлэлт 16, овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 25, эцэг, эх тогтоосны бүртгэл 15, гэрлэлтийн бүртгэл 114, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 26, нас баралтын бүртгэл 196, шилжилт хөдөлгөөний бүртгэл 744, иргэний үнэмлэхийн бүртгэл 1182, гадаад паспортын 1230 бүртгэл тус тус бүртгэгдсэн байна.

- Үндэсний энгийн цахим гадаад паспортын чиглэлээр

Иргэний улсын бүртгэлийн газрын 2023.01.11-ны 4/363 “Гадаад паспортын талаар авах арга хэмжээний тухай”, УБЕГ-ын 2023.02.28-ны 1/1774, 2023.03.03-ны 1/1895 тоот чиглэл, ИУБГ-ын 2023.04.06-ны 3/3164 тоот “Гадаад паспортын бүртгэл хөтлөх тухай” чиглэлүүдийг улсын бүртгэгч нарт тухай бүр танилцуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хэвлэгдэж ирсэн гадаад паспортыг нэг бүрчлэн нягтлан шалгаж олголт хариуцсан улсын бүртгэгчид шилжүүлэн ажиллаж байна.

Цахим гадаад паспортын хэрэглээ, ач холбогдлын талаарх мэдээллийг иргэдэд хүргэж 2023.05.18-ны өдрөөс хойш энгийн гадаад паспортын захиалга аваагүй цахим гадаад паспортыг иргэдэд олгон ажиллаж байна.

Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Булган аймаг дахь “Сайхан Монгол” телевизтэй хамтран цахим гадаад паспорт түүний хэрэглээний талаарх мэдээллийг хүргэн богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд түгээн ажилласан.

- Мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд 2007 онд бүртгүүлсэн 800 гаруй хүүхдийн ХААТР-11 маягтыг байгууллагын архиваас татан авч мэдээллийн санд шалган үүнээс **79** иргэний ургийн овог зөрүүтэй, эцэг эхийн мэдээлэл санд тусгагдаагүй зөрчлийг ХУБ-ын нэгдсэн дүгнэлтэд үндэслэн зассан.

Иргэний улсын бүртгэлийн газрын 2023.06.25-ны 3/5080 тоот албан бичгийн хүрээнд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн зөрчилтэй 6 иргэний бүртгэлийг шалгаж зөрчлийг арилгах арга хэмжээ авч бүртгэлийн зөрчлийг бүрэн арилгаж илтгэх хуудас хүргүүлсэн.

Мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд бүртгэсэн төлөвтэй 135 бүртгэлийг мэдээллийн сан, эх нотлох баримттай тулган шалгаж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллалаа. Нийт 135 бүртгэлээс 13 бүртгэлийн зөрчлийг арилгаж бусад бүртгэл дээр ХУБ-ын дүгнэлт гаргуулахаар хяналтын байцаагчид шилжүүлсэн.

- Тоон гарын үсэг олголтын чиглэлээр

Тоон гарын үсгийн олголтыг идэвхижүүлэх ажлын хүрээнд Булган аймгийн “ХААН БАНК”-тай хамтран 2023.05.01-ны өдөр тоон гарын үсэг олгох өдөрлөг зохион байгуулж 80 гаруй иргэнд мэдээлэл хүргэж тоон гарын үсэг олгосон. Мөн Булган аймгийн “Татварын хэлтэс”, ХХАА-н газар,



ХААН банк, Булган сумын 5-р багийн иргэдэд мэдээлэл хүргэж тоон гарын үсэг олгосон. 2023 оны эхний хагас жилийн байдлаар **3680** иргэнд нийт **13100** гаруй буюу нийт иргэдийн 30 гаруй хувьд олгосон байна.

1.6. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар улсын ахлах бүртгэгчийг түр орлон гүйцэтгэгч-1, улсын бүртгэгч-2, тасгийн хэмжээнд нийт 3 албан хаагчтайгаар хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үнэлж, дүгнэлт гарган, мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн нийт **6** удаагийн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг цаг хугацаанд нь хоцроосон удаагүй илтгэх хуудас хүргүүлэн тайлагнаж шуурхай ажилласан.

Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр тайлант хугацаанд нийт **2206** бүртгэл хийгдсэнээс:

- Анхны бүртгэл – 385
- Өмчлөх эрх шилжих – 433
- Барьцааны гэрээ – 1072
- Бүртгэлд өөрчлөлт оруулах -258
- Лавлагаа, хуулбар –56
- Архивын лавлагаа – 48

Нийт улсын төсөвт үйлчилгээний хураамж- **23.450.440₮** төгрөг.

Татварын орлого-**46,453,447₮** төгрөг.

Улсын тэмдэгтийн хураамж- **944,660₮** төгрөг төвлөрүүлэн ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тоон мэдээг өмнөх онуудын жилийн эцсийн тоон мэдээтэй харьцуулан авч үзвэл:

№	Үйлчилгээний төрөл		Тайлант хугацаа		
			2021 он	2022 он	2023 он /хагас жилээр/
1	Өмчлөх эрхийн анхны бүртгэл		650	809	385
	үүнээс:	Газар	302	531	240
		ГБҮХЭХ	348	246	135
		Шинээр баригдсан орон сууц	32	29	10
2	Өмчлөх эрх шилжих гэрээний эрхийн бүртгэл		690	745	433
3	Барьцааны гэрээ		2996	1522	1072
	үүнээс:	Барьцааны гэрээ дуусгавар болгох	1265	777	478
4	Бүртгэлд өөрчлөлт оруулах		268	300	258



БУЛГАН АЙМГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙНТАЙЛАН

5	Лавлагаа, хуулбар	140	61	56
6	Урьдчилсан тэмдэглэл	1	2	-
7	Хувийн хэрэг хаах	8	15	17
8	Нийт бүртгэлийн тоо	6703	3326	2206
9	Архивын лавлагаа	160	110	48
10	Албан бичиг		72	99
11	Үйлчилгээний нийт хураамж	56.392.861₮	34.535.219₮	23.450.440₮
12	Тэмдэгтийн хураамжийн нийт дүн	1.721.956₮	1.987.219₮	944,660₮
13	ҮХЭХӨЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого	168.242.678₮	114.938.540₮	46,453,447₮

1.7. Санхүүгийн чиглэлээр:

2023 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн урсгал зардалд 296723,4 мянган төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсвийн хуваарийн зүйл ангийн дагуу 296723,4 мянган төгрөгийн зарлага хийгдэж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Санхүүгийн үйл ажиллагааг цахим программаар эрхлэн хөтөлж, хуулийн хугацаанд сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг ерөнхий газарт хүргүүлж, вэб сайт, шилэн дансны системд байршуулан ажилласан.

Улсын бүртгэлийн үйлчилгээний орлого 49,4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нягтлан бодох бүртгэлийн өдөр бүр, сар бүрийн эцэст гаргадаг тайлан мэдээг хугацаанд нь хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- Сар бүрийн харилцахын баримтын бүрдэлтийг шалгаж, цэгцэлж байна.
- Санхүүжилт орсон үед цалин болон бусад гүйлгээг хийж байна.
- Нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 5-ны дотор гаргаж тоон гарын үсгээр илгээж байна.
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 1-ны дотор гаргаж, ил тод мэдээллийн самбарт байршуулсан.
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган 2023 оны эхний хагас жилийн байдлаар 16 төрлийн 73 мэдээллийг сар бүр хуулийн хугацаанд нь байршуулж хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан.
- Улирал бүр татварын тайлан хийж татварын хэлтэсээр баталгаажуулж байна.

1.8. Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Тус хэлтсийн архив нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар иргэний бүртгэлийн архивт 81791, ЭХЭБ-ийн 20713 хуулийн этгээдийн 1776 хэрэг хадгалагдаж байна.

Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:

Нийт 81791 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас хүүхдийн санд – 23555, хувийн хэрэгжсэн санд-39385, нас баралтын санд-17119, тодорхой бус иргэдийн санд –499, он тодорхой бус нас баралтын санд-1316-ыг он дараалал болон цагаан толгойн галигийн дарааллын дагуу архивт байршуулсан байгаа болно.



1951-1980 он хүртэлх бүх сумын төрөлт бүртгэлийн журналуудын урагдсан хуудасыг нааж сэргээн засаж сэлбэх ажлыг хийж гүйцэтгэв. Мөн 2022 онд хадгалах хугацаа дууссан баримтууд болон ИУБ маягтуудыг жагсаалт гаргаж байгууллагын ББНШК-оор оруулан хэлтсийн даргын 2023.03.22-ны А/05 тоот тушаалаар комисс томилогдон устгаж тайланг УБЕГ-т хүргүүлэн ажиллаа.



Иргэний 8 төрлийн бүртгэлээр болон ААН байгууллагад лавлагаа олгоход шаардлагатай архивын эх нотлох баримт болон журналыг лавлагаа хариуцсан улсын бүртгэгчид, ямар нэгэн зөрчилтэй ХУБ-дээр шалгагдах шаардлагатай иргэдийн хувийн хэрэг болон бусад шаардлагатай материалуудыг тухай бүрт нь гарган өгч ажиллаа.

Мөн шинээр 16 нас хүрч иргэний цахим үнэмлэх захиалсан 246 иргэний ИУБ-31 маягтыг ИУБ-11 маягттай хавсарган шинээр архивын хувийн хэрэг үүсгэн цагаан толгойн галигын дагуу архивт байршууллаа.

Хуулийн этгээд, ЭХЭУБ-ийн архивын чиглэлээр:

ЭХЭУБ-ийн архивт нийт 20713 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газраас бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 8558, газрын бүртгэл-10259, эзэмших газар 1887, ашиглах газар 9 –г сум тус бүрээр газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээр ангилан архивт байршуулсан байгаа болно.

2023 оны эхний хагас жилийн байдлаар ЭХЭБТ-ийн архивт шинээр газраас бусад эд хөрөнгийн хувийн хэрэг 132, газрын хувийн хэрэг 214-г шинээр нээж архивт өгсөнг журналаар хүлээн авч сум тус бүрээр шинээр хувийн хэрэг үүсгэн дугаарын дагуу байршуулж, нэмэлт үйлчилгээгээр хийгдсэн материалуудыг тухай бүрт нь журналаар хүлээн авч архивын баяжилтанд байршуулан ажилласан.

Мөн ЭХЭУБ-ын хувийн хэргүүдээс хадгалах хугацаа дууссан болон устгах шаардлагатай байгаа материалуудын жагсаалтыг гарган УБЕГ-т хүргүүлэн шийдвэрлүүлсэн ба архивт байршиж буй хувийн хэргүүдээс шаардлагагүй болсон тусгаарлах хуудсуудыг салган ялгаж ялгасан хувийн хэргүүдийг бүртгэл хөтлөн устгалд оруулсан байна.




УБЕГ-С нягтруулсан шүүгээ 3-г хэлтэсээс унаа гарган ачиж авч ирж архивт угсран багтахгүй байгаа хувийн хэргүүдийг байршуулан ажиллаж байна.



Тус тасгийн архивт 1922 хувийн хэрэг байршиж байгаагаас шинээр 155, татан буугдсан 1 бүртгэл хийгдсэн байна. Аймгийн сум дундын шүүхээс тус архивын “Зулзаган түшиг”, “Шинэ амжилт” гэх 2 компанийн хувийн хэрэгт 3 удаагийн үзлэг хийгдсэнг шаардлагатай материалыг канондах болон протокол үйлдэн буцаан архивт байршуулж ажиллалаа.

Архивын байрны галын буланг сэргээн “Гамшиг ослын үед архивын байрнаас баримт материалыг зөөвөрлөх хуваарийг хэлтсийн даргын тушаалаар томилуулан, хэлтсийн байранд гамшиг осол гарсан үед хийх дадлага сургуулийг нэг удаа зохион байгуулан галын буланд дутуу байсан хүрээ-2ш, галын цохиур, тармуур зэргийг шинээр нэмж байрлуулаа.



1.9. Мэдээлэл технологийн чиглэлээр:

- ✓ Хэлтсийн www.bulgan.burtgel.gov.mn вэбсайтыг тогтмол хөтөлж, байгууллагын онцлох үйл ажиллагаа мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр шилэн дансны мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр, хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг 3 удаа, бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээг сар бүр, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг 9 удаа нийт 80 гаруй мэдээ, мэдээллийг байршуулан ажиллалаа.
- ✓ Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Булган аймаг дахь “Сайхан Монгол” телевизтэй хамтран цахим гадаад паспорт түүний хэрэглээний талаарх мэдээллийг хүргэн богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд түгээн ажилласан.
- ✓ 2023 оны эхний хагас жилийн байдлаар “Сайхан монгол” телевиз, байгууллагын вэб сайт, пэйж хуудас зэрэг 3 төрлийн мэдээллийн хэрэгсэлээр 80 гаруй мэдээ мэдээллийг байршуулан ажилласан.
- ✓ Сүлжээний гэмтлийг, төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг засварлах ажлаар нийт 3-н сумдын компьютерын хэвийн ажиллагааг ханган ажилласан.
- ✓ Байгууллагын ажилтнуудын компьютер, түүний дагалдах хэрэгслүүдэд гарч байгаа програмын болон тоног төхөөрөмжийн гэмтлийг засварлаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

ХОЁР. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:


Булган аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цахим төлбөрийн систем болох бүх төрлийн төлбөр төлөх Гэрэгэ киоск машиныг шийдвэрлүүлэн 2023 оны 01 дүгээр сард хэлтсийн үйлчилгээний танхимд байршуулсан мөн төрийн банкны пос машиныг үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 4000 гаруй иргэн цахимаар төлбөр төлж нийт үйлчилгээний хураамжийн 95 гаруй хувийг цахим төлбөрийн системээр үзүүлсэн байна.




Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Булган аймаг дахь “Сайхан Монгол” телевизтэй хамтран цахим гадаад паспорт түүний хэрэглээний



талаарх мэдээллийг хүргэн богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд түгээн ажилласан.



2023.05.22-ны өдөр Булган аймгийн Цагдаагийн газрын Ахмадын зөвлөлийн эрх зүйн тасгаас зохион байгуулсан **“Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигыг бууруулах”** сэдэвт давтан сургалтад хэлтсийн **10** албан хаагч оролцсон. Тухайн өдөр хэлтсийн 3 албан хаагч ерөнхий газрын даргын чөлөөтэй мөн хяналтын улсын байцаагчийн орон тоо дутуу тул 4 албан хаагч хамрагдаагүй, сургалтад оролцсон албан хаагчдын ирц **100%** хамрагдсан болно.



ГУРАВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР:

Булган аймгийн Татварын хэлтэс, ХХААГазрын ажилтан албан хаагчдад бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль журмын тухай ойлголт түүний хэрэглээний талаарх мэдээллийг хүргэж ажилласан.



Тоон гарын үсгийн олголтыг идэвхижүүлэх ажлын хүрээнд Булган аймгийн “ХААН БАНК”-тай хамтран 2023.05.01-ны өдөр тоон гарын үсэг олгох өдөрлөг зохион байгуулж 80 гаруй иргэнд мэдээлэл хүргэж тоон гарын үсэг олгосон. Мөн Булган аймгийн “Татварын хэлтэс”, ХХАА-н газар, ХААН банк, Булган сумын 5-р багийн иргэдэд мэдээлэл хүргэж тоон гарын үсэг олгосон. 2023 оны эхний хагас жилийн байдлаар **3680** иргэнд нийт **13100** гаруй буюу нийт иргэдийн 30 гаруй хувьд олгосон байна.



БУЛГАН АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



ХААН БАНК



ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЖ БАЙНА

Хаан банк ХХК санхүүгийн бүх төрлийн гүйлгээ, онлайн зээлийг тоон гарын үсгээр баталгаажуулдаг болсонтой холбогдуулан **“Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх”** аян зохион байгуулж байна.

Хамрах хүрээ: Монгол улсын 16 ба түүнээс дээш насны иргэд


Үргэлжлэх хугацаа: 2023.04.03 - 2023.06.30





2023.05.03-ны өдөр “Газрын харилцааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан хамтран ажиллагч байгууллагуудын дунд зохиогдсон гар бөмбөгийн тэмцээнд 3-р байр ХҮРЭЛ медаль хүртэж мөнгөн шагналаар шагнагдсан.

Тус хэлтэс нь Монгол бичгийн сургалтыг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан, дадлага олгох ажлыг Хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Раднаабаяр хэлтсийн албан хаагчдад Үндэсний бичгээр баримт бичиг боловсруулах хичээлийг тогтмол 7 хоногийн Мягмар гаригт 2 цагийн хичээлийг зохион байгуулж ажиллаж байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй ТЭРБУМ мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн мод тарих үйл ажиллагаанд хэлтсийн албан хаагчид оролцож өмнөх онд тарьж ургуулсан модны ургалтыг шалган арчилж шинээр 3 мод суулгасан.



-----oOo-----

